



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/71


Төмөрбулаг сум

Г Шинжилгээнд хамруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/104, Аймгийн Засаг даргын А/305 захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд малын бруцеллөз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд азраганаас бусад хээлтүүлэгч малд бруцеллөз өвчний тандалт шинжилгээг 2024 оны 06 сарын 12-ны өдрөөс 08 сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж ажиллахыг мал эмнэлгийн нэгжийн эмч нарт тус тус үүрэг болгосугай.
2. Тандалт шинжилгээнд хамруулах малын тоог хавсралтаар баталсугай.
3. Тандалт шинжилгээний ажлын явцад хяналт тавьж, тайлан мэдээг хүргүүлж ажиллахыг мал эмнэлгийн тасагт даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Нямханд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ